



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2012 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 170

Мандалговь

Хөрөнгө балансаас баланст
шилжүүлэх тухай

Монгол Улсын Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 31, 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журамын 2.2 “а”, 3.2.6-гийн “б” заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Боловсрол соёлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 7902.9 мянган төгрөгний үлдэх өртөг бүхий 2005 онд ОХУ-д үйлдвэрлэсэн УАЗ фургон маркын ДУА 39-10 улсын дугаартай автомашиныг Адаацаг сумын дунд сургуульд шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тус тээврийн хэрэгслийг аймгийн Боловсрол соёлын газрын үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасаж, Адаацаг сумын дунд сургуульд холбогдох журмын дагуу бүртгэж авахыг сумын дунд сургуулийн захиралд даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНГӨНЦООЖ

63